

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/172/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адьяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/140
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАНДИНЦЭЦЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв буурч батлагдсантай холбоотой байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, санхүүжилт, орлогын эх үүсвэрийг зөв зохион байгуулан, нэн тэргүүнд эмч, ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг бууруулах зэрэг арга хэмжээг авч ажиллах талаар Эрүүл мэндийн яамны 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 2/4931 дүгээр ажлын чиглэл ирсэн байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас шалтгаалж 2025 оны 10, 11, 12 дугаар сарын 121,458.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй авлага үүссэн байна.

Аудитын гол асуудал

Шууд худалдан авалтын аргаар 20,000.0 мянган төгрөгөөс доош үнийн дүнтэй 11 удаагийн гэрээ байгуулж, нийт 109,568.8 мянган төгрөгийн худалдан авалт хийн Эрүүл мэндийн төвийн амбулаторийн байр, дөрвөн машины грашийг засаж, барилгын сайжруулалтаар бүртгэсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт бүхий нийт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг


4136020208

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

95 хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	608,041,095.79	491,737,953.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,799,792.17	73,694,100.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,799,792.17	73,694,100.45
3121	Төгрөг	142,799,792.17	73,694,100.45
31211	Төрийн сангийн харилцах	142,799,792.17	73,694,100.45
33	АВЛАГА	313,530,083.29	249,222,368.55
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	296,766,622.35	231,583,092.53
335	Бусад авлага	16,763,460.94	17,639,276.02
3351	Байгууллагаас авах авлага	16,763,460.94	17,639,276.02
35	БАРАА МАТЕРИАЛ	151,711,220.33	168,821,484.99
351	Түүхий эд материал	68,700,181.53	78,260,131.19
35110	Тусгай зориулалттай материал	2,896,742.00	2,807,665.00
35130	Эм боох материал	65,803,439.53	75,452,466.19
354	Хангамжийн материал	82,404,188.80	89,954,503.80
35410	Бичиг хэргийн материал	1,588,360.00	567,785.00
35420	Аж ахуйн материал	1,008,200.00	611,450.00
35440	Түлш, шатах тослох материал	322,500.00	00.00
35450	Барилгын засварын материал	2,182,100.00	4,160,000.00
35460	Хүнсний материал	571,350.00	552,590.00
35470	Бусад хангамжийн материал	76,731,678.80	84,062,678.80
35500	Биологийн хөрөнгө	606,850.00	606,850.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	668,323,138.54	917,449,546.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	668,323,138.54	917,449,546.70
392	Биет хөрөнгө	646,167,471.98	894,709,991.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	490,403,791.13	599,972,636.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-161,213,661.31	-64,362,074.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,646,434.00	102,370,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-59,714,628.32	-44,943,194.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	394,361,741.41	426,033,385.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-197,768,556.33	-169,810,992.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,300,305.01	36,972,969.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,733,443.55	-12,078,471.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,946,351.00	19,946,351.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-110,813.06	-1,440,569.78
39217	Ном	2,049,952.00	2,049,952.00
393	Биет бус хөрөнгө	22,155,666.56	22,739,555.56
39301	Програм хангамж	950,000.00	760,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-858,333.44	-84,444.44
39303	Бусад биет бус хөрөнгө	22,064,000.00	22,064,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,276,364,234.33	1,409,187,500.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,276,364,234.23	1,409,187,500.69

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	1,276,364,234.23	1,409,187,500.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	423,076,192.40	423,076,192.40
51101	Өмч: - төрийн	423,076,192.40	423,076,192.40
512	Хуримтлагдсан үр дүн	708,192,873.59	964,557,922.08
51210	Өмнөх үеийн үр дүн	708,192,873.59	831,734,655.63
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	132,823,266.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	145,095,168.24	21,553,386.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,276,364,234.23	1,409,187,500.69

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,585,930,012.48	1,846,713,773.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,263,773.74	312,834,398.91
120	Нийтлэг татварын бус орлого	94,263,773.74	312,834,398.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	542,400.00	12,356,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	542,400.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	12,356,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	55,398,084.80	265,248,280.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	38,323,288.94	35,230,117.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,491,666,238.74	1,533,879,374.90
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,528,100.00	80,864,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,528,100.00	80,864,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,412,138,138.74	1,453,015,174.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,412,138,138.74	1,453,015,174.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,281,283,177.71	1,713,890,507.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,281,283,177.71	1,713,890,507.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,275,955,993.54	1,700,793,787.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	802,333,379.00	1,056,485,696.83
210101	Үндсэн цалин	443,074,631.00	575,830,742.06
210102	Нэмэгдэл	287,746,387.00	387,926,243.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,922,480.00	26,197,554.00
210104	Урамшуулал	65,589,881.00	66,531,156.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,339,082.42	121,758,204.54
210201	Тэтгэврийн даатгал	70,082,764.26	81,564,551.49
210202	Тэтгэмжийн даатгал	7,838,056.44	10,401,840.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	983,800.00	6,783,062.02
210204	Ажилгүйдлийн даатгал	4,471,627.23	4,841,266.25
210205	Эрүүл мэндийн даатгал	15,962,834.49	18,167,484.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,634,554.25	70,955,780.18
210301	Гэрэл, цахилгаан	7,211,296.90	7,432,778.51
210302	Түлш, халаалт	61,423,257.35	61,423,001.67
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,561,211.00	41,342,474.00
210401	Бичиг хэрэг	3,305,601.00	6,398,805.00
210402	Тээвэр, шатахуун	22,353,690.00	24,806,819.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,406,220.00	2,351,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,495,700.00	7,785,550.00

**Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	172,951,661.48	205,814,733.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	156,287,452.14	171,078,203.22
210502	Хоол, хүнс	16,664,209.34	34,736,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,388,932.00	16,954,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000.00	265,000.00
210604	Урсгал засвар	17,308,932.00	16,689,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,724,800.00	2,590,000.00
210702	Дотоод албан томилолт	2,724,800.00	2,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,729,598.00	4,098,941.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,457,000.00	3,013,025.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	79,528.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	486,598.00	430,388.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,292,775.39	180,793,957.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,778,580.00	9,773,440.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,514,195.39	171,020,517.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,327,184.17	13,096,719.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	8,082,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,082,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,327,184.17	5,014,719.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,327,184.17	5,014,719.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	304,646,834.77	132,823,266.46
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	304,646,834.77	132,823,266.46

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,220,656,557.39	1,611,418,904.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	542,400.00	12,356,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	542,400.00	12,356,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	542,400.00	12,356,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	542,400.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	12,356,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,220,114,157.39	1,599,062,904.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,528,100.00	80,864,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,528,100.00	80,864,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,140,586,057.39	1,518,198,704.72
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,140,586,057.39	1,518,198,704.72
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,171,641,341.62	1,525,625,951.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,171,641,341.62	1,525,625,951.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,166,314,157.45	1,512,529,231.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	802,333,379.00	1,056,485,696.83
210101	Үндсэн цалин	443,074,631.00	575,830,742.06
210102	Нэмэгдэл	287,746,387.00	387,926,243.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,922,480.00	26,197,554.00
210104	Урамшуулал	65,589,881.00	66,531,156.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,339,082.42	122,634,019.62
210201	Тэтгэврийн даатгал	70,082,764.26	82,440,366.57
210202	Тэтгэмжийн даатгал	7,838,056.44	10,401,840.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	983,800.00	6,783,062.02
210204	Ажилгүйдлийн даатгал	4,471,627.23	4,841,266.25
210205	Эрүүл мэндийн даатгал	15,962,834.49	18,167,484.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,606,615.83	70,955,780.18
210301	Гэрэл, цахилгаан	8,183,358.48	7,432,778.51
210302	Түлш, халаалт	61,423,257.35	61,423,001.67
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,597,433.00	40,278,549.00
210401	Бичиг хэрэг	4,022,623.00	4,586,130.00
210402	Тээвэр, шатахуун	21,288,690.00	24,484,319.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,441,220.00	2,501,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,844,900.00	6,877,300.00

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,829,500.00
2105	Нормативт зардал	126,906,379.20	180,125,805.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	110,065,539.20	145,408,035.00
210502	Хоол, хүнс	16,840,840.00	34,717,770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,464,090.00	24,431,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,540,000.00	4,541,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,090,000.00	397,000.00
210604	Урсгал засвар	6,834,090.00	19,493,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,724,800.00	2,590,000.00
210702	Дотоод албан томилолт	2,724,800.00	2,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,729,598.00	9,168,981.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,457,000.00	8,083,065.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	79,528.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	486,598.00	430,388.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,612,780.00	5,859,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,612,780.00	5,859,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,327,184.17	13,096,719.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,082,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,082,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,327,184.17	5,014,719.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,327,184.17	5,014,719.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,015,215.77	85,792,953.27
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	148,535,323.00	154,898,645.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	148,535,323.00	154,898,645.00
2200	Дотоод эх үүсвэрээр	148,535,323.00	154,898,645.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	148,535,323.00	154,898,645.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(148,535,323.00)	(154,898,645.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(99,520,107.23)	(69,105,691.72)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	242,319,899.40	142,799,792.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,799,792.17	73,694,100.45

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,076,192.40	145,095,168.24	397,546,038.82	965,717,399.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	304,646,834.77	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,076,192.40	145,095,168.24	708,192,873.59	1,276,364,234.23
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	423,076,192.40	145,095,168.24	708,192,873.59	1,276,364,234.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	123,541,781.94	123,541,781.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	423,076,192.40	145,095,168.24	831,734,655.63	1,399,906,016.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	123,541,781.94	00.00	-123,541,781.94
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	132,823,266.46	132,823,266.46
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,076,192.40	21,553,386.30	964,557,922.09	1,409,187,500.69

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,136,265,100.00	1,611,418,904.72	524,846,195.28	75.43
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,155,200.00	80,864,200.00	291,000.00	99.64
132001	Орон нутгийн төсвөөс	81,155,200.00	80,864,200.00	291,000.00	99.64
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,033,793,900.00	1,518,198,704.72	515,595,195.28	74.65
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,033,793,900.00	1,518,198,704.72	515,595,195.28	74.65
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,316,000.00	12,356,000.00	8,960,000.00	57.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,316,000.00	12,356,000.00	8,960,000.00	57.97
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,136,265,100.00	1,675,509,876.62	460,755,223.38	78.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,136,265,100.00	1,675,509,876.62	460,755,223.38	78.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,115,829,100.00	1,667,427,876.62	448,401,223.38	78.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,306,031,700.00	1,056,485,696.83	249,546,003.17	80.89
210101	Үндсэн цалин	701,151,700.00	575,830,742.06	125,320,957.94	82.13
210102	Нэмэгдэл	429,880,000.00	387,926,243.87	41,953,756.13	90.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,500,000.00	26,197,554.00	3,302,446.00	88.81
210104	Урамшуулал	145,500,000.00	66,531,156.90	78,968,843.10	45.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,321,000.00	122,634,019.61	47,686,980.39	72.00
210201	Тэтгэврийн даатгал	114,760,700.00	82,440,366.56	32,320,333.44	71.84
210202	Тэтгэмжийн даатгал	12,202,300.00	10,401,840.02	1,800,459.98	85.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,202,300.00	6,783,062.02	5,419,237.98	55.59
210204	Ажилгүйдлийн даатгал	6,751,100.00	4,841,266.25	1,909,833.75	71.71
210205	Эрүүл мэндийн даатгал	24,404,600.00	18,167,484.76	6,237,115.24	74.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,155,200.00	70,955,780.18	5,199,419.82	93.17
210301	Гэрэл, цахилгаан	7,959,200.00	7,432,778.51	526,421.49	93.39
210302	Түлш, халаалт	66,396,000.00	61,423,001.67	4,972,998.33	92.51
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	2,100,000.00	-300,000.00	116.67
2104	Хангамж, бараа материалын зардал	68,812,900.00	40,278,549.00	28,534,351.00	58.53
210401	Бичиг хэрэг	5,502,200.00	4,586,130.00	916,070.00	83.35
210402	Тээвэр, шатахуун	44,000,000.00	24,484,319.00	19,515,681.00	55.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,310,700.00	2,501,300.00	1,809,400.00	58.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	6,877,300.00	3,122,700.00	68.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	1,829,500.00	3,170,500.00	36.59
2105	Нормативт зардал	248,488,200.00	180,125,805.00	68,362,395.00	72.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	188,488,200.00	145,408,035.00	43,080,165.00	77.14
210502	Хоол, хүнс	60,000,000.00	34,717,770.00	25,282,230.00	57.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	214,000,000.00	179,329,845.00	34,670,155.00	83.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	72,000,000.00	49,871,000.00	22,129,000.00	69.27

**Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,000,000.00	397,000.00	6,603,000.00	5.67
210604	Урсгал засвар	135,000,000.00	129,061,845.00	5,938,155.00	95.60
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	2,590,000.00	3,410,000.00	43.17
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	2,590,000.00	3,410,000.00	43.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,886,000.00	9,168,981.00	10,717,019.00	46.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,500,000.00	8,083,065.00	10,416,935.00	43.69
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	0	130,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	79,528.00	472.00	99.41
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.00	430,388.00	169,612.00	71.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,134,100.00	5,859,200.00	274,900.00	95.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,134,100.00	5,859,200.00	274,900.00	95.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,436,000.00	8,082,000.00	12,354,000.00	39.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,436,000.00	8,082,000.00	12,354,000.00	39.55
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,436,000.00	8,082,000.00	9,354,000.00	46.35
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	0	3,000,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,799,792.17		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		73,694,100.45		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 72,439.9 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд 590.6 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг шуудан холбооны зардал, 7.8 мянган төгрөгийн эмийн зардлыг бичиг хэргийн зардалд тайлагнасан.

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 4,139.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийг хандив тусламжаар тайлагнасан.

Бараа материалын тодруулга тайланд 26,120.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийг хандив тусламжаар тайлагнасан.

Тайлант хугацаанд акталсан 873.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг тайлагнаагүй.

Тайлант хугацаанд тавилга эд хогшлын данснаас Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дүгээр тогтоолоор 6,259.1 мянган төгрөг актлах шийдвэр гарснаас 5,097.8 мянган төгрөгийг данснаас хасаж, 1,161.3 мянган төгрөгийн дутуу тайлагнасан.

Нийгмийн даатгалын 612.1 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.

Тайлант хугацаанд бодогдсон 14,103.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 24,839.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авах тушаал гаргаагүй бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасны дагуу санхүүгийн тайлан залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 12,812.6 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1.Өмнөх оноос он дамжсан их засварын үлдэгдэл 16,741.9 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлж дуусгаагүй, өмнөх аудитын албан шаардлагыг биелүүлээгүй ажилласан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн:Он дамжсан авлагыг бүрэн барагдуулах зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2.Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 57 ширхэг 41,160.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэл, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3 "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд 590.6 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг шуудан холбооны зардалд 7.8 мянган төгрөгийн эмийн зардлыг бичиг хэргийн зардал тус тус тайлагнасан.	1	590.6			1	590.6	1	590.6		
2	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 4,139.1 мянган төгрөгийн хөрөнгийн хандив тусламжаар тайлагнасан.	1	4,139.1			1	4,139.1	1	4,139.1		
3	Бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 26,120.0 мянган төгрөгийн материалыг хандиваар авсан мөрөнд буруу тайлагнасан.	1	26,120.0			1	26,120.0	1	26,120.0		
4	Санхүүгийн байдлын тайланд акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 873.3 мянган төгрөгийг тусгаагүй.	1	873.3	1	873.3			1	873.3		
5	Тайлант хугацаанд тавилга эд хогшлын данснаас Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дүгээр тогтоолоор 6,259.1 мянган төгрөг актлах шийдвэр гарснаас 5,097.8 мянган төгрөгийг данснаас хасаж, 1,161.3 мянган төгрөгийн дутуу тайлагнасан.	1	1,161.3			1	1,161.3	1	1,161.3		
6	Авлагын 612.1 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	612.1	1	612.1			1	612.1		
7	Тайлант хугацаанд бодогдсон 14,103.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.	1	14,103.8	1	14,103.8			1	14,103.8		
8	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 24.839.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авах тушаал гаргаагүй.	1	24,839.8			1	24,839.8	1	24,839.8		
	Дүн	8	72,439.9	3	15,589.2	5	56,850.7	8	72,439.9		

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-							1	-				
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 57 ширхэг 41,160.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1					-				
3	Өмнөх оноос он дамжсан их засварын үлдэгдэл 16,741.9 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй, өмнөх аудитын албан шаардлагыг биелүүлээгүй.	1				1					-				
	Дүн	3				2				1					

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 145 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 26 мэдээлэл, байршуулаагүй 1 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,419,099.8 мянган төгрөгийн 35 гүйлгээ, зарлагын 199,733.5 мянган төгрөгийн 23 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 9,054.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны тайлан болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	1,627,887.9	-	-	1	1,627,887.9	-	-
Дүн	1	-						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шууд худалдан авалтын аргаар Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн амбулаторийн байр, дөрвөн машины грашийг нийт 109,568.8 сая төгрөгийн урсгал засварын ажил хийгдсэн.	1	109,568.8					1	109,568.8
Дүн	1	109,568.8					1	109,568.8
Нийт дүн	1	1,737,456.8			1	1,627,887.9	1	109,568.8



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 67-20810579-ТӨА-2026/172/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 57 ширхэг 41,160.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7 “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Нямдаваа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 66-20810579-ТӨА-2026/172/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оноос он дамжсан их засварын үлдэгдэл 16,741,860 /арван зургаан сая долоон зуун дөчин нэгэн мянга найман зуун жаран мянга/ төгрөгийн ажлыг гүйцэтгүүлж дуусгаагүй авлагыг бүрэн барагдуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг бүрэн барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Нямдаваа нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны
санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 68-20810579-ТӨА-2026/172/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь, 26 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,419,099.8 мянган төгрөгийн 35 гүйлгээ, зарлагын 199,733.5 мянган төгрөгийн 23 гүйлгээний мэдээлэл хугацаа хоцорч, орлогын 9,054.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандинцэцэг, нягтлан бодогч Д.Нямдаваа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn